

Зээлд хамрагдах төсөлд тавигдах шаардлага

5.1. Төсөл нь үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэл, зах зээлийн судалгаа, эдийн засгийн тооцоо, дүгнэлт, хавсралт гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд эхлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт сайжруулалт, дуусгавар болох хугацааг тодорхой заасан байна.

5.2. Төсөл хэрэгжүүлэгчийн тухай мэдээлэлд дараахь зүйлийг тусгана:

5.2.1. төслийн товч агуулга;

5.2.2. хуулийн этгээдийн нэр;

5.2.3. а. үйлдвэр, үйлчилгээ, худалдаа эрхэлж буй хаяг байршил;
б. хуулийн этгээдийн албан ёсны хаяг;
в. төсөл хэрэгжих байршил

5.2.4. төслийн нийт хөрөнгө оруулалтын 30-аас доошгүй хувийг өөрийн эх үүсвэрээс бүрдүүлэхээр санхүүгийн тооцоололд тусгасан байх;

5.2.5. үйлдвэрлэл, үйлчилгээ болон худалдах бүтээгдэхүүний нэр, төрөл, танилцуулга;

5.2.6. одоогийн эрхэлж байгаа бизнесийн талаарх мэдээлэл.

5.3. Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны үйл ажиллагааны тухай мэдээлэлд дараахь зүйлийг тусгана:

5.3.2. түүхий эдийн чанарын үзүүлэлт, нөөц;

5.3.1. үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны технологийн ажиллагаа;

5.3.3. үйлдвэрлэлийн хүчин чадал;

5.3.4. хэрэгжүүлэх төсөлд шаардагдах тоног төхөөрөмжийн жагсаалт.

5.4. Удирдлага зохион байгуулалт болон хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэлд дараахь зүйлийг тусгана:

- 5.4.1. бүтэц, орон тоо;
 - 5.4.2. ажиллагсдын мэргэжил, мэргэшил, ур чадвар;
 - 5.4.3. шинээр бий болгох ажлын байрны тоо.
- 5.5. Зах зээлийн судалгаанд дараахь мэдээллийг тусгана:
- 5.5.1. зах зээлийн судалгаа;
 - 5.5.2. хэрэглэгчийн судалгаа;
 - 5.5.3. гадаад, дотоод орчны (SWOT) шинжилгээ.
- 5.6. Эдийн засгийн тооцоонд дараахь мэдээллийг тусгана:
- 5.6.1. үндсэн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний нийт орлого;
 - 5.6.2. төслийн борлуулалтын орлогын тооцоо;
 - 5.6.3. үйлдвэрлэлийн зардлын тооцоо;
 - 5.6.4. бүтээгдэхүүний өртгийн тооцоо;
 - 5.6.5. бүтээгдэхүүний борлуулалтын төлөвлөгөө;
 - 5.6.6. үйлдвэр, үйлчилгээ, худалдааны үр ашгийн тооцоо;
 - 5.6.7. төслийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалд хамрагдах тооцоо;
 - 5.6.8. хөрөнгө оруулалтын тооцоо (өөрийн хөрөнгө оруулалтын хэмжээ, зээлийн зарцуулалтын тооцоо);
 - 5.6.9. төслийн өгөөж, хөрөнгө оруулалтыг нөхөх хугацаа.
- 5.7. Шинээр бизнес эхэлж байгаа тохиолдолд энэ журмын 5.2.6 дахь заалт хамаарахгүй.
- 5.8. Төслийн дүгнэлтэд энэ журмын 5.4-5.6-д заасан тооцоо судалгаанд үндэслэн төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн, эрсдэл зэргийг тооцоолсон мэдээллийг тусгана.